



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн, “Амгалан дулааны станц” ТӨХК-ийг 116 МВт-ын хүчин чадалтай зуухаар өргөтгөхтэй холбоотой Эрчим хүчний сайдын ирүүлсэн хүсэлт болон “Амгалан дулааны станц” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д худалдах дулааны тарифыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан тарифыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Амгалан дулааны станц” ТӨХК (Ш.Баянмөнх), “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК (Г.Баярсайхан)-д тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Эрхэмбаяр)-нд даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ


Э.САМДАН

ЗОХИЦУУЛАГЧ

Ц.НОРОВЖАМЦ



Эрчим хүчний зохицуулах хорооны
2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
444 дүгээр тогтоолын хавсралт



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХУДАЛДАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д худалдах дулааны энергийн тариф

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	төг/Гкал	19,200.0
2	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	төг/Гкал	23,041.0
3	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	төг/Гкал	24,033.0
4	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	төг/Гкал	25,475.0
5	2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	төг/Гкал	27,003.0
6	2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	төг/Гкал	28,623.0

2. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д худалдах дулааны чадлын тариф

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	мян.төг/сар	2,454,354.6
2	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	мян.төг/сар	3,083,918.2
3	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	мян.төг/сар	2,614,525.8
4	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	мян.төг/сар	1,726,435.3
5	2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	мян.төг/сар	1,633,266.1
6	2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөх тариф	мян.төг/сар	1,404,758.8